



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠦ-ᠠᠯᠭᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А1257

Алтай хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны тэргүүлэх зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд малын гаралтай түүхий эдийг боловсруулах нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн бий болгох үйлдвэр байгуулах "Алтайн малчдын түншлэл" төслийг үр дүнтэй хэрэгжүүлэн сум, аймгийн түвшинд хоршоо, компаниудыг байгуулах, хамтран ажиллуулахад мэргэжил арга зүйн хувьд дэмжлэг үзүүлэн ажиллах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Сумдын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийг сумдаа байгуулж, тус ажлын хүрээнд 2023 онд малчдын гар дээрээс малын гаралтай түүхий эд болох хонины ноос, ноолуурыг сумд үйл ажиллагаа явуулж буй хоршоо, аж ахуйн нэгжтэй хамтран бэлтгэн нийлүүлж, малчдын орлогыг нэмэгдүүлэх, боловсруулах үйлдвэрт хувь хөрөнгө нийлүүлэх хэлбэрийн ажлыг чанартай зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Төслийг хэрэгжүүлэгч ажлын хэсэг болон малчдын төлөөллийг гадаадын үйлдвэрүүдэд туршлага судлах ажлыг цаг алдалгүй зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны  
09 дугаар сарын 27-ны өдрийн 1627 дугаар  
захирамжийн хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Ш.Эрдэнэбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Гишүүд:
- Л.Хаш-Эрдэнэ (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
  - Б.Золжаргал (Хууль эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
  - Х.Баатарзориг (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
  - Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
  - Т.Эрхэмбаяр ("Инноваци судлагаа бизнес хөгжлийн төв" УТҮГ-ын захирал)
  - С.Эрдэнэ-Очир (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны дарга)
  - С.Даваасамбуу ("Даваа файкон" ХХК-ийн гүйцэтгэх захирал зөвшилцсөнөөр)  
Сумдын Засаг дарга
- Нарийн бичгийн дарга: С.Баярмаа (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)